

Mongolian-German Financial Cooperation

Biodiversity and Adaptation to Climate Change - Phases I, II and III -

KfW Monitoring Mission 18th-23 May 2021

Minutes of Meeting

In May 2021, a KfW Mission, comprising of Mr. Michael Sumser (Director of KfW-Office Mongolia) and Ms. Enkhzul Tseveg (National Project Coordinator, KfW UB) undertook the delayed annual Progress Review for 2020 of all three phases of the **Biodiversity and Adaptation to Climate Change Programme” (BACCP)**. They held discussions with relevant Project Partners on the phases I to III of the programme and visited the project areas in Central and Western Mongolia. Discussions were held with senior staff of the Ministry of Environment and Tourism (MET), notably MET’s State Secretary, Mr. D. Ganbold, as well as Mr. T. Boldbaatar of DRPAM (Dept. of Regional Protected Area Management), who accompanied the mission during the field visit, and other representatives of the Aimags, Soums and Bufferzone Councils. The mission was excellently organised by the BACCPs Project Implementation Unit (PIU) its Director Ms.G.Erdenebayasgalan and Ms. Ts. Enkhsaikhan who both accompanied the mission as well on the field visit. And the Implementation consultant (IC) Mr. P.Galragchaa and Mr. G. Gansukh. Field visits covered the Phase II and III, clusters 3-5, which are Ikh Bogd National Park (NP), Khar Us Nuur Special Protected Areas (SPA). The Otgon Tenger SPA, Tarvagatai Nuruu NP, Khangain Nuruu NP, Khugnu Tarna NP, Khorgo Terkh NP, and Orkhon Valley NP which were visited are part of Phase I. The Mission also met with representatives of GIZ, WWF, TNC, in Hovd.

The Mission expressed its appreciation for the excellent, highly efficient and productive working atmosphere during the discussions and field visits as well as for the outstanding hospitality and support received by all officials and all other persons met.

The Mission pointed out that all statements and remarks given represent the Mission's position only. All understandings reached are subject to approval by KfW management and by the German Government. Likewise, those understandings are also subject to approval by the Minister for Environment and Tourism.

The following sections contain the Mission’s discussion points and results on the review of Phase I (section 1) as well as Phases II/III (section 2).

Review of BACCP I

1.1. Overall/summary assessment

The Mission congratulates MET, the PIU and the IC for the substantial advancements made in implementing Phase I of the Programme and expressed strong appreciation of their high levels of commitment and professionalism in implementing their work. As to the remaining duration of Phase I, all parties stick to the agreed Termination of BACCP I at the end of 2021. This allows sufficient time to carry out all foreseen activities, incl. those in support of the buffer zones, and thereby to contribute to the sustainable achievement of objectives. The Mission stressed the need for MET/Ministry of Finance (MoF) to keep up efforts to ensure that the Government of Mongolia provides counterpart funding equivalent to the amounts agreed upon in the Financing- and Separate Agreement for Phase I – in addition to MET's regular budget for the Protected Area (PA) network. In terms of concept and project results, significant improvements at PA level – on the one hand – could be noted in the areas visited. BACCP equipment and infrastructure has evidently contributed to the high levels of motivation and morale of PA staff met in the field. On the other hand, the envisaged support to sustainable livelihoods in the PA buffer zones (in addition to the buffer zone fund, BZF) is not yet demonstrating satisfactory progress at significant scale.

1.2. Field visits and delivered goods

As during their previous monitoring visits, the KfW Mission stressed that all delivered goods will require regular maintenance in order to ensure the sustainability of their use (cf. MoM signed in June 2019 and 2018, Aug. 2017 and Sep. 2016) and that securing such funds lies within the responsibility of MET. According to the data available, each PAA has a separate budget line to cover for "renovation expenses" (infrastructure and supplies) which varies widely between 1% and 10% of the PAA's total budget. This budget line is not specifically earmarked for the goods and works funded as part of BACCP. The Mission pointed out that maintenance funds need to increase proportionally to the amount of goods and works funded under the Programme and that regular monitoring of functionality and maintenance should be carried out by MET/PIU during field trips. It was already 2019 agreed that, MET/PIU jointly with the IC will develop a concept on the operation and maintenance (O&M) of the delivered goods and works for submission to KfW which outlines respective O&M responsibilities beyond the duration of the Project and which includes a budget calculation of the government funds required to ensure adequate maintenance. Until now this concept is still under Preparation.

1.3. Programme management

1.3.1. Programme duration

All sides had agreed that the completion of BACCP I in the originally envisaged period of 5 years until May 2020 was not realistic and that an extension until the end of 2021 was necessary. The

now ongoing extension is allowing for sufficient time to carry out the remaining tenders and activities, particularly those related to the pilot projects and buffer zone activities (in addition to the BZF).

Related to this, the Mission reiterated that the Livelihood improvement activities such as the foreseen Buffer Zone Fund (Budget 400,000 EUR) and Livelihood measures in the Buffer Zone of Tarvagatain Nuruu SPA (Budget 96,000 EUR) constitute very important conceptual pillars to the Program. In addition, the construction of a sanitary facility in the extension of the Tarvagatain Nuruu NPAA's building (64,000 EUR) requires urgent attention (as well on KfW's side) in order to be finalized in Phase I and prior to the next winter.

The Bufferzone Fund is about to start in five Soums, the respective contacts are ready for signing (or have already been signed) by the three Parties involved (Bufferzone Councils, MET and State Bank of Mongolia). To the extent that they are successful, it is expected that the pilot projects plus the BZF will be extended and scaled up during Phase II/III of the Programme. Expected savings from Phase I activities could as well be added to the Bufferzone Fund.

1.3.2. Allocation of remaining funds

Out of the total Financial Contribution (11.5 million EUR) 9.029.330 EUR have been spent (transferred from KfW to the Disposition Fund account) as of May 17, 2021, the complete rest is reserved for contracts signed, but not yet disbursed, or already been allocated for specific activities (tenders under preparation/in process and BZF).

1.3.3. Mongolian Counterpart contribution

The cumulative GoM contribution to the BACCP I until End of 2020 amounts to 2,99 Billion MNT (approx. 0,85 million EUR) which has exclusively been used for the funding of the PIU (running costs). According to the current forecasts for 2021, GoM contributions to finance the PIU will amount to 690 million MNT (approx. 200.000 EUR) for BACCP I-III. The Mission welcomes the amount of counterpart funds that has been provided for the Programme so far and emphasized that the remaining counterpart contribution should be availed regularly year by year until the end of the programme. According to the Sep. Agreement for BACCP I, 6.65 billion MNT are foreseen only for phase I in terms of the Mongolian contribution. Thus, approx. 3.66.billion MNT still need to be availed for phase I.

Currently the discussions on which cost and payments of MET to the PAs can be recognized by KfW as Local Contribution are ongoing between PIU, MET and KfW. Thus the issue of Local Contribution and which payments are acceptable for KfW will be agreed separately from this MoM by MET, PIU and KfW.

It should be mentioned that the local contribution to the PIU as well as the O&M budget for the PAs have increased significantly during the project implementation period. (PA O&M Budget 2016: 509 million MNT (170.000 EUR) to 2020: 1,242 million MNT (414.000) but still is insufficient compared to the amounts needed for proper Maintenance of existing infrastructure and vehicles.

1.3.4. Procurement

Discussions between KfW and the PIU continue to seek ways to accelerate the still too slow procurement process and the time required for the various approval steps of KfW. Based on KfW's Procurement Department's advice, for small tenders below 20.000 EUR, Direct Award procedure is now being used. No "No-Objection-Letter" from KfW is required for these small amount procurements but Mongolian procedures have to be followed. For procurements between 20.000 EUR and 100.000 EUR LCB (limited competitive bidding) procedure should more frequently be used. Here as well the approval procedure from KfW side is easier and quicker.

As mentioned in KfW's recent communication with MET and MoF as well as during the German-Mongolian Governmental Negotiations in 2018 and 2020, bilateral agreements shall prevail over national regulations in case of inconsistencies. Nevertheless, as the KfW Guidelines are much more general than the Mongolian Procurement Law in many cases the stricter and often slower procedures of the Mongolian Procurement law are followed.

1.4. Programme Components

1.4.1. Component 1

All activities under Component 1 are completed. Only additional construction works at the Khustai NP are ongoing and the printing tasks of books, leaflets, and brochures for the PA's has still to be completed.

1.4.2. Component 2

Investment Activities are still ongoing and the PIU intends to invest the highest amount of all years in 2021. All the toilet construction activities, started in 2020 are nearly completed. Amongst others a tender for the procurement of 4x4 Vehicles (Russian Microvan) to transport rangers in the PAs is still ongoing.

Buffer Zone Fund (BZF): The Mission pointed out that the BZF – like the other pilot projects mentioned before – is considered of high conceptual relevance (despite their modest budget volume). Moreover, the BZF addresses one of Mongolia's key environmental concerns (over-grazing and related pasture degradation). The Volume of the BZF will initially be 400.000 EUR and implementation of this pilot will start in 5 Soums. The fund will be implemented in cooperation with the State Bank of Mongolia who will administer the small loans.

Social infrastructure: in 2020 16 ambulance vehicles were procured and distributed to the Buffer Zone Soums as well as 48 "Eco Cabinets" (furnitures and learning materials). The Mission pointed out that MET needs to ensure that sufficient funds for the operation and maintenance of these goods are guaranteed by the respective line ministries.

1.4.3 Component 3

Extensions on pilot projects (connectivity, biodiversity, pasture and forest) and 3 other small direct award activities are ongoing.

1.4.4. Component 4

Most activities are completed but some direct award activities, including monitoring & evaluation activities, public awareness campaign (short video, printing materials) and trainings, seminars, open-day activities, closing ceremony etc. are still ongoing.

The Construction of the Regional Training Centre (RTC) in Tsetserleg has been completed and was visited during the field trip. The Centre is being used, both as an office for the PAA as well as for trainings. A tender for IT equipment for the RTC was awarded. During the field visit the Mission advised again that the respective PAA will carry out a final inspection of the building, listing all deficiencies that need to be addressed by the construction company prior to the termination of the warranty period.

1.5 General Remarks:

- The Mission pointed out the need for MET to enable the possibility of independent funding for all PAs in addition to the pure budget allocation in order to generate enough funds for operation and maintenance of the PAs. This requires changes to the law and regulations of the PAs.
- Furthermore, the mission clearly noted that the quality of the construction works seen during the field trip requires improvement and can only be classified as just acceptable.
- The mission and the PIU recommend to develop standards regarding the quality and design of the PA staff uniforms and regarding the design of camp sites and barbeque places to avoid repeated discussions about layout and other basic issues. The PIU, MET and the IC should develop and agree these standards.
- It might be useful to standardize as well the basic equipment of the rangers and the ranger posts in order to allow them to fulfill their various tasks.
- On request of the PIU the mission reassured that from KfW's point of view the transfer of funds that could not be fully used until the end of Phase I is not an issue and can be done on the basis of informing KfW of the respective amounts.
- PIU proposes to do a final amendment of the cost table of the Separate Agreement for Phase I in order to have the final spending at the end of phase I in line with the Separate Agreement.

Implementation of BACCP II/III

2.1. Current status

Phase II and III have started March 2020 with the IC taking up his assignment. Offices in Khovd and Uvs for the PIU and the IC have been established and staff has been recruited. Vehicles have been procured and handed over to the local offices. The cluster concept has been widely explained to the local administrations and all stakeholders in cooperation with the "Spaces Project" of GIZ. Preparatory measures, and the implementation of management concepts is nearing completion and procurements are starting in the next months. Construction works will follow 2022. ESMF (social and environmental studies) as well as base line studies are part of the preparatory work.

The geographical focus of Phase II/III is on the country's Western and South-Western parts. There was unanimous agreement that an adequate local presence of both the PIU as well as the IC is needed and has been implemented. Both the IC and the PIU have motivated, well qualified and sufficient staff in the regional office in Khovd.

As is the case for BACCP I, annual procurement plans for BACPP II/III have been developed by the IC together with the PIU and submitted to KfW for their review.

In order to promote an efficient implementation, both sides agreed that Phase II/III shall have relatively fewer but larger procurements.

Signed in Ulaanbaatar on July 1st, 2021

For MET



Mr. D. Batmunkh
Project National Director

For MET



Mr. D. Ganbold
State Secretary



For the KfW Mission

Mr. Michael Sumser
Director KfW Mongolia

Монгол-Германы санхүүгийн хамтын ажиллагаа
Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын
өөрчлөлтөд дасан зохицох төсөл
- 2 ба 3 дугаар үе шат –

2021 оны 5 дугаар сарын 18-23-нд KfW банкнаас
гүйцэтгэсэн үнэлгээний ажлын
хурлын тэмдэглэл

2021 оны 5 дугаар сард Майкл Зумзер (KfW Улаанбаатар - төлөөлөгчийн газрын захирал), Ц.Энхзул (KfW Улаанбаатар - төслийн зохицуулагч) нараас бүрдсэн KfW банкны үнэлгээний баг нь 2020 оноос хойшлогдоод байсан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн (БОЯБХУАӨДЗТ) 1, 2, 3 дугаар шатны үйл явцын үнэлгээг хийлээ. Монгол орны төв болон баруун бүс нутгууд руу зорчиж, төслийн 1, 2, 3 дугаар үе шатны үйл ажиллагааны талаар холбогдох хүмүүстэй уулзав. Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны удирдах ажилтнууд, онцолж хэлбэл, БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, мөн үнэлгээний багт ажилласан Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн М.Болдбаатар (ТХБНУГ) болон аймаг, сум, орчны бүсийн зөвлөлийн бусад төлөөлөгчидтэй уулзаж ярилцав. БОЯБХУАӨДЗТ-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) - ийн захирал, Г.Эрдэнэбаясгалан, ажилтан Ц.Энхсайхан нар үнэлгээний ажлыг туйлын сайн зохион байгуулж оролцов. Мөн төслийн зөвлөх баг (ЗБ)-аас П.Галрагчаа, Г.Гансүх нар ажиллалаа. Төслийн 2, 3 дугаар үе шатанд хамрагддаг 3, 5 дугаар кластерын нутаг болох Хар ус нуурын тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН), Их Богдын байгалийн цогцолборт газар (БЦГ) (одоогоор хамрагдаагүй байгаа), түүнчлэн төслийн 1 дүгээр үе шатанд хамрагддаг Отгон Тэнгэрийн ТХГН, Тарвагатай Нуруу БЦГ, Хангайн Нуруу, Хөгнө Тарна БЦГ, Хорго Тэрх БЦГ, Орхоны Хөндийн БЦГ-ын захиргаадын ажилтай танилцав. Ховд аймагт Германы олон улсын хамтын ажиллагаа (GIZ), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), Начур консерванси (TNC) зэрэг төсөл, хөтөлбөрийн төлөөлөлтэй уулзаж ярилцлаа.

Орон нутагт ажиллах явцад өндөр үр ашигтай, үр бүтээлтэй, тааламжтай орчин нөхцөлийг бий болгож, удирдах ажилтнууд болон бусад бүх хүмүүсийн зочломтгой байдал, дэмжлэгт үнэлгээний багийн зүгээс талархаж байгаагаа илэрхийлэв.

Үнэлгээний багийн зүгээс өгч байгаа мэдэгдэл, тайлбар нь зөвхөн үнэлгээний багийн байр суурийг илэрхийлж байгааг онцлон тэмдэглэв. Хүрсэн бүх ойлголтыг KfW-ийн удирдлага болон Германы засгийн газар эцэслэн батална. Үүний нэгэн адил эдгээр ойлголтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд батлах ёстой.

Үнэлгээний багаас төслийн 1 (1-р хэсэг), 2, 3 (2-р хэсэг) дугаар үе шатны ажлыг хянаж, үр дүнгийн талаар дүгнэлт өгснийг дор хавсаргав.

БОЯБХУАӨДЗТ-ийн 1 дүгээр шатны ажлын үнэлэлт, дүгнэлт

1.1. Ерөнхий/товч үнэлгээ

Үнэлгээний багийн зүгээс төслийн 1 дүгээр шатыг хэрэгжүүлэхэд дорвитой ахиц үзүүлж, үйл ажиллагаандаа хичээл зүтгэл гарган мэргэжлийн хэмжээнд ажилласныг өндрөөр үнэлж Байгаль орчин аялал жуулчлалын яам, төсөл хэрэгжүүлэх нэгж, төслийн зөвлөх багт баяр хүргэлээ. БОЯБХУАӨДЗТ-ийг 2021 оны сүүлээр цуцлах-ын хүрээнд төслийн 1 дүгээр үе шатыг хэрэгжүүлж дуусгана гэдэг дээр бүх талууд санал нэгдэв. Энэ нь орчны бүсийг дэмжих, ингэснээрээ зорилгодоо хүрэхэд чиглэгдсэн, төлөвлөгөөт бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хангалттай хугацаа болно. Төслийн 1 дүгээр үе шатанд зурагдсан Санхүүгийн болон Тусгай Гэрээний дагуу ТХГН-ийн сүлжээнд БОАЖЯ-аас өгдөг ердийн төсвөөс гадна монголын талаас хийгдэх ёстой зохих санхүүжилтийг гүйцэлдүүлэх тал дээр БОАЖЯ/Сангийн яам (СЯ)-ны зүгээс хүчин чармайлтаа үргэлжлүүлэх шаардлагатай байгааг үнэлгээний багийнхан тэмдэглэв. Орон нутагт ажиллах явцад Тусгай хамгаалалттай газар (ТХГН) -ийн түвшинд төслийн үзэл баримтлал, үр дүнгийн хувьд томоохон ахиц дэвшил гарсан нь ажиглагдав. БОЯБХУАӨДЗТ-өөс хангасан тоног төхөөрөмж, дэд бүтэц нь орон нутагт уулзсан ТХГН-ийн ажилтнуудын хүсэл эрмэлзэл, ёс суртахууныг өндөр түвшинд өргөхөд нөлөөлсөн нь дамжиггүй хэдий ч нөгөө талаар ТХГН-ийн орчны бүсийн иргэдийн тогтвортой амьжиргааг хангахад дэмжлэг үзүүлэх (ОБС - орчны бүсийн сангаас гадна) ажилд дорвитой ахиц дэвшил гараагүй байна.

1.2. Томилолт, тоног төхөөрөмж

Өмнөх мониторингийн айлчлалын үеэр KfW банкны үнэлгээний багаас хөрөнгө оруулалтын хүрээнд олгогдсон бүх бараа бүтээгдэхүүнийг тогтвортой ашиглах үүднээс байнгын засвар үйлчилгээ шаардагдах болно, мөн түүнд зарцуулах хөрөнгө мөнгөний асуудал нь БОАЖЯ-ны хариуцлагын хүрээнд багтана гэдгийг дахин онцлов. Өгсөн мэдээллээс харахад ХЗ бүрт "засварын зардал" (дэд бүтэц, хангамж) -ын тусгай төсөв байдаг ба энэ нь ХЗ-ны нийт төсвийн 1,0 -10 хувийн хооронд хэлбэлздэг. Энэхүү төсвийг БОЯБХУАӨДЗТ-ийн хүрээнд санхүүжүүлсэн тоног төхөөрөмж, барилга байгууламжид тусгайлан зориулаагүй болно. Төслийн хүрээнд санхүүжүүлж буй тоног төхөөрөмж, барилгын тоо, хэмжээтэй дүйцүүлэн засвар үйлчилгээний санхүүжилтийг пропорциональ хэмжээгээр нэмэгдүүлэх, үйл ажиллагаа, засвар үйлчилгээний байнгын хяналтыг БОАЖЯ/ТХН-аас газар дээр нь очиж танилцах үеэр хийх шаардлагатай байгааг үнэлгээний баг тэмдэглэв. 2019 онд, БОАЖЯ / ТХН нь төслийн зөвлөх багтай хамтран санхүүжилтийн хүрээнд олгогдсон тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засвар үйлчилгээний үзэл баримтлалыг боловсруулж, KfW банканд хүргүүлэхээр тохирсон. Уг үзэл баримтлалд төсөл дууссаны дараа мөрдөх засвар үйлчилгээтэй холбоотой асуудлууд, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай засгийн газрын төсвийн тооцоо зэрэг орох юм. Өнөөг хүртэл энэхүү үзэл баримтлалын боловсруулалт дуусаагүй байна.

1.3. Төслийн менежмент

1.3.1. Төслийн үргэлжлэх хугацаа

БОЯБХУАӨДЗТ -ийн 1 дүгээр үе шатыг анх төлөвлөсөн ёсоор 5 жилийн хугацаанд буюу 2020 оны 5 дугаар сар хүртэл хэрэгжүүлж дуусгах боломжгүй байсан тул 2021 оны эцэс хүртэл сунгах шаардлагатай гэдэг дээр бүх талууд санал нэгдсэн. Төслийн сунгалтын хугацаа нь загвар төслүүдтэй болон орчны бүсийн үйл ажиллагаатай холбоотой (ОБС-аас гадна) зарлагдаагүй тендер, хийгдээгүй ажлуудыг гүйцэтгэхэд хангалттай хугацаа юм.

Үүнтэй холбоотойгоор, орчны бүсийн сангийн (Төсөв 400,000 евро) хүрээнд, мөн Тарвагатайн нурууны БЦГ-ын орчны бүсийн (Төсөв 96,000 евро) иргэдийн амьжиргааг дээшлүүлэх төлөвлөгөөт үйл ажиллагаанууд нь төслийн чухал үзэл баримтлалын тулгуур багана болж байгааг үнэлгээний баг дахин онцлов. Нэмж дурдахад Тарвагатайн нурууны БЦГ-ын барилгын өргөтгөлийн ариун цэврийн байгууламжийг (64,000 евро) 1 дүгээр үе шатанд багтаах, мөн өвөл болохоос урьтаж дуусгахын тулд яаралтай анхаарал (KfW-ийн зүгээс ч) хандуулах шаардлагатай байна.

Орчны бүсийн сангийн ажил таван суманд эхлэхээр болоод байгаа ба холбогдох талууд болох ОБЗ, БОАЖЯ, Төрийн банк нь гэрээнд гарын үсэг зурах гэж (эсвэл аль хэдийн зурсан) байна. Эдгээр ажил хэр амжилттай хэрэгжсэнээс шалтгаалан төслийн 2, 3 дугаар үе шатанд тэдгээр загвар төслүүд, мөн түүнчлэн ОБС-г өргөтгөж, томруулан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. 1 дүгээр үе шатны үйл ажиллагаанаас хүлээгдэж буй хэмнэлтийг ОБС -д нэмж оруулах боломжтой.

1.3.2. Үлдсэн санхүүжилтийг хуваарилах

2021 оны 5 дугаар сарын 17-ны байдлаар нийт санхүүжилтээс (11.5 сая евро) 9.029.330 еврог зарцуулсан (KfW банкнаас Тусгай данс руу шилжүүлсэн) ба үлдэгдэл хэсгийг гэрээнүүдэд гарын үсэг зурсаны дараа шилжүүлэхээр үлдээсэн, хараахан олгоогүй эсвэл тодорхой үйл ажиллагаанд зориулан хуваарилсан (тендерүүд бэлтгэл / дунд шатандаа яваа, ОБС) байна.

1.3.3. Монголын талын санхүүжилт

2020 оны төгсгөл гэхэд БОЯБХУАӨДЗТ -ийн 1 дүгээр үе шатанд оруулах монголын талын санхүүжилтийн 2.99 тэрбум төгрөг (ойролцоогоор 0,85 сая евро) зөвхөн ТХН-ийн санхүүжилтэд зарцуулагдсан (урсгал зардал). 2021 оны энэ үеийн урьдчилсан таамаглалаар ТХН-ийг санхүүжүүлэхэд МУ-ын оруулсан санхүүжилт нь БОЯБХУАӨДЗТ-ийн 1-3 дугаар үе шатанд 690 сая төгрөг (ойролцоогоор 200.000 евро) болохоор байна. Үнэлгээний багаас төсөлд оруулж буй монголын талын хөрөнгө оруулалтын хэмжээг сайшааж байгаа бөгөөд төсөл дуусах хүртэл үлдсэн хөрөнгө оруулалтыг жил жилд нь тогтмол шилжүүлэх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв. БОЯБХУАӨДЗТ -ийн 1 дүгээр үе шатны Тусгай гэрээнд тусгасны дагуу төслийн зөвхөн 1 дүгээр үе шатанд 6.65 тэрбум төгрөгийг Монгол Улсын санхүүжилтээс оруулахаар тооцсон болно. Тиймээс, 1 дүгээр үе шатанд ойролцоогоор 3.66. тэрбум төгрөгийг оруулах шаардлагатай хэвээр байна.

Одоогийн байдлаар ТХН, БОАЖЯ, KfW-ийн хооронд яамнаас ТХГН-т төсөвлөж байгаа ямар өртөг, төлбөрийг KfW-ийн зүгээс монголын талын хөрөнгө оруулалт хэмээн хүлээн зөвшөөрөх талаар хэлэлцүүлэг явагдаж байна. Тиймээс, монголын талын санхүүжилтийн энэ асуудал, мөн ямар төлбөрийг KfW хүлээн зөвшөөрөх талаар энэ хурлын тэмдэглэлээс тусад нь БОАЖЯ, ТХН, KfW нар тохиролцох болно.

Төсөл хэрэгжүүлэх хугацаанд ТХН болон ТХГН-ийн засвар үйлчилгээний төсөвт монголын талын хөрөнгө оруулалтын хувь хэмжээ ихээхэн нэмэгдсэнийг дурдах хэрэгтэй. (ТХГН-ийн засвар үйлчилгээний төсөв 2016: 509 сая төгрөг (170.000 евро) байснаас 2020 онд: 1.242 сая төгрөгт (414.000)) хүрсэн боловч одоогийн дэд бүтэц, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд шаардагдах хэмжээтэй харьцуулахад хангалтгүй хэвээр байна.

1.3.4. Худалдан авалт

KfW ба ТХН-ийн хооронд хэтэрхий удааширч байгаа худалдан авалт болон KfW-ээс алхам бүрд авдаг зөвшөөрөлд зарцуулдаг хугацааг түргэсгэх арга замыг эрэлхийлсэн хэлэлцүүлэг хийгдэж байна. KfW-ийн Худалдан авах ажиллагааны газрын зөвлөмжид үндэслэн 20.000 еврогоос бага үнэтэй тендер шалгаруулалтад Шууд гэрээ байгуулах журмыг ашиглаж байна. Эдгээр бага үнэтэй худалдан авалтад KfW-ээс "Үл татгалзах" авах шаардлагагүй боловч Монгол Улсын журмыг дагаж мөрдөх ёстой. 20.000 - 100.000 еврогийн худалдан авалтад ХТ (хязгаарлагдмал тендер)-ийн журмыг илүүтэй ашиглах хэрэгтэй. Ингэснээр KfW-ийн зөвшөөрлийн явц хялбар бөгөөд хурдан болно.

KfW-ээс саяхан БСЯ болон СЯ-тай, түүнчлэн Герман, Монголын Засгийн газар хоорондын 2018, 2020 оны хэлэлцээрийн үеэр дурдсанчлан, маргаантай тохиолдолд тухайн улсын бус, хоёр талын гэрээг дагаж мөрдөнө гэж заасан. Гэсэн хэдий ч KfW-ийн удирдамж нь Монгол Улсын Худалдан авах ажиллагааны тухай хуулиас хавьгүй ерөнхий байдаг тул хатуу журамтай, ихэвчлэн удаан явцтай байдаг Монгол Улсын Худалдан авах ажиллагааны тухай хуулийг мөрддөг.

1.4. Төслийн бүрэлдэхүүн хэсэг

1.4.1. Бүрэлдэхүүн хэсэг 1

Бүрэлдэхүүн хэсэг 1-ийн бүх үйл ажиллагаа дууссан. Хустай БЦГ-т зөвхөн нэмэлт барилгын ажил үргэлжилж байгаа бөгөөд ТХГН-ийн ном, товхимол, эвхмэл хэвлэх ажлыг дуусгах шаардлагатай байна.

1.4.2. Бүрэлдэхүүн хэсэг 2

Хөрөнгө оруулалтын ажил одоо ч үргэлжилж байгаа бөгөөд ТХН-ийн зүгээс 2021 онд хамгийн их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөсөн. 2020 онд эхлүүлсэн ариун цэврийн өрөөний барилгын ажил үндсэндээ дуусаж байна. Бусад тендерээс гадна ТХГН-ийн байгаль хамгаалагчдын унаанд ашиглах 4x4 тээврийн хэрэгсэл (Орос фургон)-ийн худалдан авах тендер одоо хүртэл үргэлжилж байна.

Орчны бүсийн сан (ОБС): Өмнө дурдагдсан загвар төслүүдийн нэгэн адил ОБС-г концепцийн хувьд өндөр ач холбогдолтой (төсвийн хэмжээ нь бага ч гэсэн) гэж үнэлгээний багийн зүгээс тооцдог болохыг тэмдэглэжээ. Нэмж хэлэхэд, ОБС нь монгол улсын хувьд тулгамдаад байгаа гол асуудлын нэгийг (бэлчээрийн даац хэтрэлт болон түүнтэй холбоотой бэлчээрийн доройтол) хөнддөг юм. ОБС-ийн хэмжээ нь эхний удаад 400.000 евро байх бөгөөд энэхүү туршилтыг 5 суманд хэрэгжүүлж эхэлнэ. Энэхүү санг Төрийн банктай хамтран жижиг зээл гаргах замаар хэрэгжүүлнэ.

Дэд бүтэц: 2020 онд 16 тооны түргэн тусламжийн автомашин, мөн орчны бүсийн 48 суманд "Эко кабинет" (тавилга, сургалтын хэрэглэгдэхүүн) худалдан авч, тараав. Эдгээр барааны ашиглалт, засвар үйлчилгээнд шаардагдах хөрөнгө мөнгөний асуудлыг холбогдох салбар яамдаас баталгаажуулж өгөхийг үнэлгээний баг БОАЖЯ-аас хүслээ.

1.4.3. Бүрэлдэхүүн хэсэг 3

Загвар төслүүдийг (холбоос нутаг, биологийн олон янз байдал, бэлчээр, ой) сунгах, мөн 3 жижиг шууд гэрээний ажил явагдаж байна.

1.4.4. Бүрэлдэхүүн хэсэг 4

Үйл ажиллагааны ихэнх хэсэг дууссан боловч мониторинг, үнэлгээний үйл ажиллагаа, олон нийтэд сурталчлах компанит ажил (богино хэмжээний видео, хэвлэх материал), сургалт, семинар, нээлттэй өдөрлөг, хаалтын ажиллагаа зэрэг шууд гэрээний зарим ажил үргэлжилж байна.

Цэцэрлэг дэх Бүсийн сургалтын төвийн (БСТ) барилгын ажил дуусаж, газар дээр нь очиж танилцлаа. Энэхүү төвийг ХЗ-ны албан өрөө болон сургалтын зорилгоор ашиглаж байна. БСТ-ийн цахим тоног төхөөрөмжийн тендерийг шалгаруулсан. Орон нутагт ажиллах үеэрээ үнэлгээний багийн зүгээс холбогдох ХЗ-нд хандан баталгаат хугацаа дуусахаас өмнө тухайн барилга байгууламжид эцсийн хяналт шалгалт хийж, дутуу зүйлсийн жагсаалт гарган барилгын компаниар шаардлагатай бүх ажлыг гүйцэтгүүлэхийг дахин зөвлөв.

1.5. Ерөнхий дүгнэлт

- ТХГН-ийн ашиглалт, засвар үйлчилгээнд зарцуулах хангалттай санхүүжилттэй байхын тулд төсвийн хуваарилалтаас гадна бие даасан санхүүжилтийг бий болгох боломжийг яамны зүгээс хийх шаардлагатай байгааг үнэлгээний баг онцолсон. Үүний тулд ТХГН-ийн хууль, журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.
- Цаашлаад, үнэлгээний ажлын үеэр үзсэн барилгын ажлын чанарыг сайжруулах шаардлагатай бөгөөд зөвхөн хүлээн зөвшөөрөх боломжтой гэсэн ангилалд орж байгаа гэдгийг тодорхой тэмдэглэв.
- Үнэлгээний баг болон ТХН-ээс ХЗ-дын ажилчдын дүрэмт хувцасны чанар, хийц, отоглох хоноглох цэг, мах шарах талбайн зурагтай холбоотой стандарт боловсруулахыг зөвлөж, ингэснээр зураг төсөл болон бусад үндсэн асуудлын талаар дахин дахин хэлэлцүүлэг хийхээс зайлсхийх юм гэв. ТХН, БОАЖЯ, зөвлөх багтай хамтран эдгээр стандартуудыг боловсруулах шаардлагатай.
- Байгаль хамгаалагчдыг ажлаа гүйцэтгэх боломжоор хангах үүднээс байгаль хамгаалагчийн байр, үндсэн тоног төхөөрөмжийг стандартчилах нь зүйтэй болов уу.
- ТХН-ийн хүсэлтээр үнэлгээний баг KfW-ийн зүгээс 1 дүгээр үе шатыг дуусахаас өмнө санхүүжилтээ бүрэн авч чадахгүй гэх асуудал байхгүй, KfW-д холбогдох хэмжээг мэдэгдсэний үндсэн дээр авах боломжтой гэж тайлбарлав.
- Тусгай Гэрээнд заасны дагуу 1 дүгээр үе шатны төгсгөл гэхэд сүүлийн зарлагаа хийхийн тулд Тусгай Гэрээний зардлын хүснэгтэд эцсийн нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгов.

БОЯБХУАӨДЗТ-ийн 2, 3 дугаар үе шатны хэрэгжилт

2.1. Одоогийн нөхцөл байдал

Зөвлөх баг ажлаа хүлээн авснаар 2020 оны 3 дугаар сард төслийн 2, 3 дугаар үе шат эхэлсэн. Зөвлөх баг, ТХН-ийн орон нутаг дахь салбарууд Ховд, Увс аймагт байгуулагдан, хамт олноо бүрдүүлэн ажиллуулж байна. Тээврийн хэрэгсэл худалдан авч орон нутаг дахь салбаруудад хүлээлгэн өглөө. Кластерийн үзэл баримтлалыг GIZ-ийн

“SPACES” төсөлтэй хамтран орон нутгийн удирдах ажилтнууд болон оролцогч бүх талуудад ойлголт, тайлбар өгсөн. Бэлтгэл арга хэмжээ, менежментийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажил дуусах шатандаа орж, худалдан авалтыг ойрын саруудад эхэлнэ. Барилга угсралтын ажил 2022 оноос явагдана. БОННМ (Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн судалгаа) болон суурь судалгаа нь бэлтгэл ажлын нэг хэсэг юм.

2, 3 дугаар үе шатны газарзүйн төв нь тус улсын баруун болон баруун өмнөд хэсэгт байна. Орон нутагт ТХН болон ЗБ-ийн орон тоо шаардлагатай гэдэгт санал нэг байсан ба энэ нь ч хэрэгжсэн. Ховд дахь бүсийн салбарт ЗБ, ТХН-ийн урам зориг бүхий, чадварлаг, хангалттай боловсон хүчинтэй байна.

БОЯБХУАӨДЗТ-ийн 1 дүгээр үе шаттай нэгэн адил төслийн 2, 3 дугаар үе шатны худалдан авалтын жилийн тайланг ТХН, ЗБ -тай хамтран гаргаж, KfW руу явуулж батлуулдаг.

Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд 2, 3 дугаар үе шатанд цөөн боловч том хэмжээний худалдан авалт хийх хэрэгтэй гэдэг дээр талууд харилцан тохиролцлоо.

Улаанбаатар хот, 01.07., 2021

БОАЖЯ-г төлөөлж
төлөөлж

БОАЖЯ-г төлөөлж

KfW үнэлгээний багийг

Д.Батмөнх

Д.Ганболд

Майкл Зумзер

Төслийн үндэсний

Төрийн нарийн

KfW ТГ-ын захирал,

захирал

бичгийн дарга

Монгол улс

Хавсралт:

- ТХН-ийн үнэлгээний тайлан
- Нээлттэй болон нээгдэх тендерүүдийн явц